



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 25/22

Улаанбаатар хот

“Дулааны тавдугаар цахилгаан станц”  
орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн  
газар байгуулж, дүрэм батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2. “Дулааны тавдугаар цахилгаан станц” ОНӨААТҮГ байгуулсантай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай:

2.1. баталсан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэх;

2.2. тус газрын бүтэц, орон тоог батлах;

2.3. үйл ажиллагааны зардлыг нийслэлийн төсвийн холбогдох зардлаас санхүүжүүлж, нэгдсэн удирдлагаар хангах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн хороо (Б.Сэмжидмаа)-нд даалгасугай.

ДАРГА

А.БАЯР